

ТОДРУУЛГЫН ХАРИУ

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах тендертэй холбоотой тодруулга албан бичиг ирсэний дагуу дараах тодруулгыг хүргүүлж байна. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/716 тоот, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/759 тоот, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/875 тоот албан бичгийн дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-т заасан шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/875 тоот албан бичигт техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах агуулга тусгагдаагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь заалтын дагуу техникийн тодорхойлолтод заасан "... үйлдвэрлэгчийн тодорхойлолт болон үйлдвэрлэгчээр баталгаажуулж тамгалсан инженерүүдийн сургалтын гэрчилгээний хуулбар нь Монгол улсын ГХЯ-ны консулын газраар дамжуулан баталгаажуулан тендерт хавсарган ирүүлнэ" гэсэн шаардлагыг хасах боломжгүй.

Харин гадаад улсад үйлдэгдсэн аливаа баримт бичгийг тендерт ирүүлэх тохиолдолд тухайн улсын албан ёсны холбогдох байгууллагаас баталгаажуулж олгосон Апостиль гэрчилгээ болон Консулын баталгаажилтыг Монгол улсын ГХЯ-ны тухайн улс дахь Элчин сайдын яам, эсхүл Консулын газраар монгол хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг баталгаажуулан тендерт ирүүлж болно.